



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 039/03 дугаар актыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгалийн гэнэтийн аюул галд өртсөнөөс сэргээн засварлах боломжгүй болсон 3 нэр төрлийн нийт 639,700.00 /зургаан зуун гучин есөн мянга долоон зуун/ төгрөгийн балансын үнэ, 378,443.32 /гурван зуун далан найман мянга дөрвөн зуун дөчин гурван төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ



000012<sup>3</sup>



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн  
179 дугаар тогтоолын хавсралт

Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Бүгд үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ширээ	2009.11.01	1	169,900.00	169,900.00	164,236.66	5,663.34
2	Шүүгээ /Тумбочек/	2009.11.01	1	109,900.00	109,900.00	106,236.66	3,663.34
3	Төмөр сейф	2016.07.01	1	359,900.00	359,900.00	107,970.00	251,930.00
	<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>639,700.00</b> /зургаан зуун гучин есөн мянга долоон зуун/	<b>639,700.00</b> /зургаан зуун найман мянга дөрвөн зуун дөчин гурван тегрөг гучин хоёр мөнгө/	<b>378,443.32</b> /гурван зуун далан найман мянга дөрвөн зуун дөчин гурван тегрөг гучин хоёр мөнгө/	<b>261,256.68 /хоёр зуун жаран нэгэн мянга хоёр зуун тавин зургаан төгрөг жаран найман мөнгө/</b>